

Түүх 8 : Анхны чуулган

Библийн эшлэл
[Үйлс 2:4]

Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв.

Есүс загалмай дээр цовдлогдон нас бараад гурав хоногийн дараа амилсан юм.

Тэгээд амилсанахаа дараа дэлхий дээр 40 өдөр амьдраад 40 дэх өдрөө тэнгэр лүү явсан юм.

Есүсийг тэнгэрт одсоны дараа дагалдагч нар нь дээврийн өрөөнд цуглаж залбирдаг байв.

Тэнд Есүсийн дагалдагч нар, Мариа мөн Есүсийг дагаж байсан эмэгтэйчүүд гэх мэтчилэн бүгд цугларсан байв. Тэд ингэж хамтдаа цуглаж нэг сэтгэлээр залбиралд нэгдэж байв. Ингээд арван өдөр өнгөрч байтал Иудейчүүдийн баяр болон Пентэкоост баяр болов.

Энэ өдөр ч гэсэн тэд баяр гэж амралгүйгээр дээврийн өрөөнд цуглан залбирч байлаа.

Гэтэл гэнэт тэнгэрээс маш хүчтэй салхины чимээ сонсогдож тэр чимээ дээврийн өрөөг дүүргэв.

Яг энэ үйл явдалтай зэрэгцэн халуун гэрэлт гал мэт хэлүүд хаялж дагалдагч нарын толгой дээр буув.

Есүс энэ дэлхий дээр байхдаа амласан Ариун Сүнс тэдний дээр буусан байв.

Ариун Сүнсээр дүүрсэн хүн бүр өөрийн мэдэлгүй өөрсдийн ч мэдэхгүй хэлээр ярьцгааж эхлэв.

Петр хүмүүст Бурханы үгийг дамжуулж эхлэв. “Есүс тэнгэрт одсоны дараа Есүсийн айлдсан бүх үгийг хүмүүст ойлгуулахын тулд Ариун Сүнс бууж ирсэн юм. Бурхан та бүхнийг бүгдийг нь аврахын тулд Есүсийг илгээсэн юм аа.”

Петрийн сургаалийг сонссон хүмүүс түүнээс ийн асуув. “Тэгвэл одоо бид нар яах вэ?” Петр ингэж хариулав.

“Гэмшигтүн, Есүсийн нэрээр бптисм хүртэцгээ. Тэгвэл та нар гэмийн уучлалыг авах болно.” Петрийн хэлсэн үгэнд олон хүн урамшин сэтгэл нь хөдлөв.

Тэр өдөр Петрийн хэлсэн үгэнд итгэж усан баталгаа хүртсэн хүний тоо гурван мянга хол давав.

Үүнээс хойш дагалдагч нар нь Есүсийн тухай ярих бүрд олон хүн итгэж Бурхан уруу эргэж ирсэн гайхамшигтай зүйлүүд бий болсоор байв. Есүсийн дагалдагч нар, Есүст итгэсэн хүмүүс өдөр бүр сүмд цуглан залбирч Бурханд талархаж байв.


Тэгээд тэд өөрсдийн хөрөнгийг зарж ядууст хуваан өгч туслаж байлаа. Ариун Сүнс буун ирсэний дараа иймэрхүү зүйлүүд бий болж үүнийг ажиглан харж байсан хүмүүс Есүсийн дагалдагч болон итгэгч хүмүүсийг шагшин магтаж Бурханд итгэж аврагдаж байлаа. Энэ бол анхны чуулганы төрх юм.



Бүтээлч байцгаая 1.

Өнөөдрийн сурсан зүйлээ бодонгоо, доорх чуулганы зураг төслийг өнгөөр ялган будаж, хайчилж, аваад чуулганыг босгон байгуулаарай.

Хэрэглэгдэх зүйлс: Хайч, Цавуу, Өнгийн харандаа.



Жишээ зураг





● Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Үйлс 2:4)

Тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч,